

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ц.УРАНЧИМЭГ ТАНАА

2020.02.18 № 06/516
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 26 дугаар зүйлийн 26.1 заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон бусад стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН ТАЙЛАН

2.1. ОРШИЛ

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Ц.Уранчимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй урамшуулал олгохгүй байх, ажилтан, албан хаагчдын шагнал урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл суутгаж, зөв тооцоолж байх, үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөж, төлөвлөгөөг биелүүлж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 3-наас 2020 оны 2 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Пийк ОМ Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/43 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Олон улсын түвшинд хүрсэн арьс-харшил, эмчилгээний гоо заслын тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэхэд оршино.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Арьсны өвчин судлалын тусламж үйлчилгээ.
- Аварга тосон сувиллын үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээтэй холбоотой;
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, илүү цагийн нэмэгдэл хөлс олгох, ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад шагнал, урамшуулал олгохтой холбоотой;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Интерактив Би Ай” ХХК-ийн “Эмералд” программ хангамж ашигладаг байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Арьсны өвчин судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал”-г сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,346,808.4 мянган төгрөгөөс тооцон 33,468.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 38,471.6 мянган төгрөгөөр тооцсон нь Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал” 3,847,161.4 мянган төгрөгөөс тооцсонтой холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 163,771.0 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	734.70	2,503.10	1,768.40
Урьдчилгаа			
Бараа материал	140,023.69	145,071.67	5,048.02
Үндсэн хөрөнгө	4,050,786.15	3,880,198.74	(170,587.41)
Нийт хөрөнгө	4,191,544.54	4,027,773.51	(163,771.03)
Өр төлбөр		26,069.45	26,069.45
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,191,544.54	4,001,704.06	(189,840.48)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,191,544.54	4,027,773.51	(163,771.03)

Авлага дансны үлдэгдэл өссөн нь татаас санхүүжилтийн авлага болон хувь хүмүүсээс авах авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Арьсны өвчин судлалын үндэсний төвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэл болон бусад шаардлагатай бараа материал бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө нь төсвийн урсгал санхүүжилтээр 54,187.4 мянган төгрөг, Эрүүд мэндийн яам болон “Пи жэй брус” ХХК-ийн хандиваар 113,145.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн болон тооллогоор 4,390.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг илрүүлж нийт 171,722.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 5 дугаар сарын 21-ний 200 тоот тогтоол, 2019 оны 5 дугаар сарын 30-ын А/1214 тоот албан бичгийн дагуу өртгөө бүрэн

нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 156,816.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл нэмэгдсэн нь тайлант онд ХХОАТ-ын болон байгууллагад төлөх өр төлбөрүүдийн өсөлтөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,027,773.5 мянган төгрөг болж 163,771.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь тайлант онд 389,655.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 379,511.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 97.4 хувиар биелүүлсэн байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн хэвтэн эмчлүүлэгчдийн дунд төрөөс үйлчилгээний төлбөрийг нь даадаг тэтгэвэр тогтоолгосон иргэд болон 18-аас доош насны хүүхдүүдийн эзлэх хувийн жин өссөн, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар клиникийн 3-р тасагт хуанлийн 50 хоног их засвар хийснээс өвчтөн хүлээж авах боломжгүй байсан зэргээс шалтгаалж үндсэн үйл ажиллагааны орлого 10,144.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,856,938.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,856,938.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 145,025.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,856,938.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 389,655.4 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,379,079.6 мянган төгрөг буюу 99.45 хувьтай байгаа нь төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг дутуу бүрдүүлснээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 10,740.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 147,646.0 мянга, нийт 158,386.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 27,906.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 4,885.7 мянга, гэрэл цахилгаанд 1,354.0 мянга, хангамж, бараа материалын зардалд 23,541.6 мянга, нормативт зардалд 19,461.7 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 49,616.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжид 2,560.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 3,062.4 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 7,000.0 мянга, нийт 139,388.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 18,997.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 62,011.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 20,705.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,405.5 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 23,621.0

мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 12,279.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Үүнд:

1. Арьсны өвчин судлалын үндэсний төв нь 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан боловч тус төвийн захирлын 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн Б/67 дугаар тушаалаар захирал өөртөө болон санхүүгийн ажилтнуудад 5,405,501 /Таван сая дөрвөн зуун таван сая таван зуун нэгэн/ төгрөгийн балансын урамшуулал олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тайлант онд тус төв нь ХХОАТ-ын 23,621.0 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, “6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал нь албан хаагчдад цалинтай чөлөө олгохдоо Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2019 оны А/11 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг дагаж мөрдөөгүй байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д “Ажил олгогч нь ажилтанд түүний хүсэлтээр чөлөө олгож болно”, 80.2-д “Чөлөөтэй байгаа хугацаанд тэтгэмж олгох, эсэх асуудлыг хамтын ба хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд зааснаар зохицуулна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 12,279.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн эмчлүүлэгчийн хоолны өртгийг технологийн картын дагуу тооцоолохдоо бохир жингээр биш цэвэр жинг ашигласан байгааг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,528.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос бүрэн барагдуулж, 41,271.8 мянган төгрөгийн зөрчлийг

арилгах 7 албан шаардлага хүргүүлснээс 41,271.8 мянган төгрөгийн 7 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Аварга тосон рашаан сувиллын ажлын ачаалал, нөхцөл байдлыг харгалзан тус төвийн захирал тушаал гаргаж, гэрээт ажилчдад хөдөлмөрийн гэрээнд тусгагдаагүй урамшуулалд 1,000.0 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үрэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид нэмэлт орлогоос гэрээт ажилчдад урамшуулал олгох шалгуурыг тодорхой болгож, хөдөлмөрийн гэрээнд тусгах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 12 албан хаагчдын шагнал урамшууллаас 667.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв, тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Нийгмийн даатгалын болон бусад хууль тогтоомж зөрчигдөх, нягтлан бодох бүртгэл буруу хөтлөгдөх

2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

3. Орлогын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн хэвтэн эмчлүүлэгчдийн дунд төрөөс үйлчилгээний төлбөрийг нь даадаг тэтгэвэр тогтоолгосон иргэд болон 18-аас доош насны хүүхдүүдийн эзлэх хувийн жин өссөн, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар клиникийн 3-р тасагт хуанлийн 50 хоног их засвар хийснээс өвчтөн хүлээж авах боломжгүй байсан зэргээс шалтгаалж 2019 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 10,144.4 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй байх эрсдэлтэй байна.

3.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөж, төлөвлөгөөг биелүүлж байх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

4. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант онд хийгдсэн 467.8 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримт нь тухайн байгууллагын регистрээр шивэгдээгүй, хувь иргэнд олгогдсон, сугалааны дугаартай и-баримт байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлд тусгагдах

4.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг хэрэгжүүлэх

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллана.

5. *Тэтгэвэрт гарсан албан хаагчдын цалин хөлстэй холбоотой асуудал*

5.1. Илрүүлэлт:

Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчдыг урьд хашиж байсан албан тушаалд эргүүлэн томилж цалин, нэмэгдэл хөлсийг хэвээр олгож байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2, 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4-д заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2. Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчигдөх;

5.3. Өгсөн зөвлөмж

Тэтгэвэрт гарсан албан хаагчдыг ажиллуулах зайлшгүй шаардлагатай бол хөдөлмөрийн гэрээ байгуулж цалин хөлсийг тогтоох

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид дээрх зөрчлийг гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>140,758,390.02</u>	<u>147,574,774.41</u>
33	АВЛАГА	734,698.17	2,503,100.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	208,993.17	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	525,705.00	2,137,500.00
335	Бусад авлага	00.00	365,600.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	365,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	140,023,691.85	145,071,674.41
351	Түүхий эд материал	88,709,924.05	111,486,417.54
35130	Эм боох материал	88,709,924.05	111,486,417.54
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,661,219.75	1,716,979.00
354	Хангамжийн материал	38,652,548.05	31,868,277.87
35410	Бичиг хэргийн материал	00.00	5,128,382.00
35420	Аж ахуйн материал	26,531,756.61	12,800,505.00
35440	Түлш, шатах тослох материал	177,413.30	2,201,730.87
35460	Хүнсний материал	11,943,378.14	9,723,160.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	2,014,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,050,786,146.39</u>	<u>3,880,198,736.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,050,786,146.39	3,880,198,736.40
392	Биет хөрөнгө	3,848,350,344.79	3,679,262,934.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,207,087,798.60	3,207,087,798.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,816,816.42)	(157,086,503.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	145,609,300.00	145,609,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(68,591,940.30)	(87,884,440.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,522,640,717.06	1,521,499,667.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,058,353,966.41)	(1,113,026,749.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	374,671,336.20	417,396,389.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(273,910,923.94)	(259,347,367.02)
39217	Ном	5,014,840.00	5,014,840.00
393	Биет бус хөрөнгө	202,435,801.60	200,935,801.60
39301	Програм хангамж	45,529,538.00	45,529,538.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(20,786,216.40)	(22,286,216.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	177,692,480.00	177,692,480.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,191,544,536.41</u>	<u>4,027,773,510.81</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>26,069,453.12</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	26,069,453.12
413	Өглөг	00.00	26,069,453.12
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	23,931,953.12
4136	Бусад өглөг	00.00	2,137,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	2,137,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,191,544,535.96</u>	<u>4,001,704,057.24</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,191,544,535.96	4,001,704,057.24

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,470,206,581.32	2,470,206,581.32
51101	Өмч: - төрийн	2,470,206,581.32	2,470,206,581.32
512	Хуримтлагдсан үр дүн	(678,669,127.63)	(868,509,606.35)
51210	Өмнөх үеийн үр дүн	(678,669,127.63)	(678,669,127.63)
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(189,840,478.72)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,400,007,082.27	2,400,007,082.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,191,544,535.96</u>	<u>4,027,773,510.36</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,252,573,481.00	3,657,651,875.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	307,651,529.00	468,259,540.00
120	Нийтлэг татварын бус орлого	307,651,529.00	468,259,540.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	307,651,529.00	380,379,540.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	296,919,720.00	367,895,036.17
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,731,809.00	12,484,503.83
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	87,880,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,944,921,952.00	3,189,392,335.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	178,499,500.00	145,025,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	178,499,500.00	145,025,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166,422,452.00	187,515,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,611,400.00	39,869,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	142,811,052.00	147,646,010.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,600,000,000.00	2,856,851,525.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,600,000,000.00	2,856,851,525.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,346,282,659.72	3,847,161,353.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,346,282,659.72	3,847,161,353.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,191,696,464.33	3,792,773,116.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,701,205,469.80	2,026,978,960.02
210101	Үндсэн цалин	1,701,205,469.80	2,026,978,960.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	203,815,659.49	277,624,766.75
210201	Тэтгэврийн даатгал	203,815,659.49	277,624,766.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,121,271.33	114,308,065.13
210301	Гэрэл, цахилгаан	55,683,746.00	53,278,163.50
210302	Түлш, халаалт	33,993,467.80	27,956,558.63

210303	Цэвэр, бохир ус	28,444,057.53	33,073,343.00
2104	Хангамж, бараа материалын зардал	102,886,043.88	107,268,609.09
210401	Бичиг хэрэг	12,845,878.50	24,317,762.00
210402	Тээвэр, шатахуун	9,480,286.70	8,978,082.43
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,099,999.66	6,600,257.66
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,641,064.71	48,346,313.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,818,814.31	19,026,194.00
2105	Нормативт зардал	653,747,880.59	775,289,161.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	493,772,295.95	544,134,876.52
210502	Хоол, хүнс	146,243,214.86	216,814,050.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,732,369.78	14,340,235.00
